

**БАТЛАВ.
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД
ХЭРГИЙН САЙД**

**БАТЛАВ.
ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР,
НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН
САЙД**

Б.ЭНХБАЯР

Т.АУБАКИР

2025 оны 10 дугаар сарын 24-ний өдөр

ГЭР БҮЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл, шаардлага

Монгол Улсын Үндсэн хуулийн¹ Арван зургадугаар зүйлийн 11-д "улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй. Гэрлэлт нь хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёрын тэгш эрх, сайн дурын харилцаанд үндэслэнэ. Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална." гэж заасан.

Түүнчлэн Монгол Улсын Үндсэн хуулийн² Арван есдүгээр зүйлийн 1-д "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна" гэж заасан байна.

Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичигт "Хүн амын тогтвортой өсөлтийг дэмжиж идэвхтэй, бүтээлч иргэн, гэр бүлийг төлөвшүүлнэ." гэж заасан.³

"Хүний эрхийн түгээмэл тунхаглал"⁴-ын Арван зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт "Насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хүмүүс арьс, яс үндэс, шашин шүтлэгтэй холбогдсон аливаа хязгаарлалтгүйгээр гэрлэх, өрх тусгаарлах эрхтэй. Мөн гэрлэгчид гэрлэхдээ, гэрлэснийхээ дараа болон гэрлэлтээ цуцлуулах үед тэгш эрх эдэлнэ" гэж, мөн зүйлийн 2 дахь хэсэгт "Эрэгтэй, эмэгтэй хоёр хүн чөлөөтэй харилцан бүрэн зөвшөөрсөн нөхцөлд гэрлэж болно" гэж, мөн зүйлийн 3 дахь хэсэгт "Гэр бүл бол нийгмийн жам ёсны үндсэн нэгж мөн бөгөөд нийгэм, төрөөр

¹ Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэлийн 1992 оны 2 дугаарт нийтлэгдсэн.

² Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэлийн 1992 оны 2 дугаарт нийтлэгдсэн.

³ "Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого батлах тухай" Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтын Зорилт 2.3.

⁴ Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Нэгдсэн Үндэстний Байгууллагын Ерөнхий Ассамблейн 217/A/III/ тогтоолоор 1948 оны 12 дугаар сарын 10-ны өдөр батлагдсан.

хамгаалуулах эрхтэй.” гэж тус тус заасныг үндэслэн улс орнууд Гэр бүлийн тухай хууль болон түүнтэй адилтгах бусад хуулиар гэр бүлийн харилцааг зохицуулдаг.

Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 141 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэлийн 1.6.52-т Гэр бүлийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төслийг Хууль зүй, дотоод хэргийн яам Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамтай хамтран боловсруулж, 2025 онд УИХ-д өргөн мэдүүлэхээр заасан.⁵

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн 2.1.1.2-т “Гэр бүлийн тухай хуулийг шинэчлэн батлуулж, чанартай амьдрал, гэр бүлийн гишүүдийн оролцоо хөтөлбөрийг хэрэгжүүлнэ.” гэж заасан болно.⁶

Монгол Улс нь Үндсэн хуульдаа тунхагласан хүний эрх, эрх чөлөөг хангах баталгааг бүрдүүлэх, ялангуяа гэр бүл бол нийгмийн үндсэн нэгж болохын хувьд төрөөр хамгаалуулах эрхийг хангах үүднээс бие даасан Гэр бүлийн тухай хуулийг⁷ 1999 онд баталсан хэдий ч хувьсан өөрчлөгдөж буй нийгмийн харилцаа, тэр дундаа гэр бүлийн харилцааг бүрэн зохицуулж чадахгүй буюу Гэр бүлийн тухай хууль өдгөө 26 жилийн турш зарчмын шинжтэй өөрчлөлт огт хийгдэлгүй үйлчилж байна.

Энэхүү 1999 онд батлагдсан Гэр бүлийн тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойших хугацаанд нийт 8 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан ч эдгээр нь гэр бүлийн харилцаанд тулгамдаад байгаа асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн гэхээс илүүтэй бусад хуулийн шинэчлэлийг дагалдсан нэмэлт, өөрчлөлт байсан.

Тухайлбал, 2002 онд Иргэний хууль,⁸ 2011 онд Нотариатын тухай хууль,⁹ 2012 онд Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль,¹⁰ 2018 онд Иргэний улсын бүртгэлийн тухай хууль,¹¹ 2021 онд Соёлын тухай хууль,¹² 2024 онд Хүүхэд хамгааллын тухай хууль¹³ тус тус батлагдсантай холбоотой Гэр бүлийн тухай хуульд тус тус нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.

Түүнчлэн энэхүү хууль нь 2002 онд батлагдсан Иргэний хуулийн суурь үзэл баримтлалтай нийцэхгүй байдал практикт үүссэн, цаашлаад хувьсан өөрчлөгдөж буй гэр бүлийн харилцааг бүрэн зохицуулж чадахгүйгээс гэр бүлийн харилцааны олон асуудал, тухайлбал хүүхэд, гэр бүлийн гишүүдийн эрхийг бүрэн хамгаалж чадахгүй байна.

⁵ “Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл батлах тухай” Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 181 дүгээр тогтоолын хавсралтын 1.6.52.

⁶ “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолын хавсралтын 2.1.1.2.

⁷ Гэр бүлийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэлийн 1999 оны 30 дугаарт нийтлэгдсэн.

⁸ Иргэний хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэлийн 2002 оны 7 дугаарт нийтлэгдсэн.

⁹ Нотариатын тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэлийн 2011 оны 9 дугаарт нийтлэгдсэн.

¹⁰ Эвлэрүүлэн зуучлалын тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэлийн 2012 оны 25 дугаарт нийтлэгдсэн.

¹¹ Иргэний улсын бүртгэлийн тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэлийн 2018 оны 28 дугаарт нийтлэгдсэн.

¹² Соёлын тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэлийн 2021 оны 32 дугаарт нийтлэгдсэн.

¹³ Хүүхэд хамгааллын тухай хууль, Төрийн мэдээлэл эмхэтгэлийн 2024 оны 30 дугаарт нийтлэгдсэн.

Харин бусад улс орнуудын жишгээс үзэхэд, гэр бүлийн гишүүдийн эд хөрөнгийн эрх буюу гэрлэгчдийн дундаа хэсгээр өмчлөх, эсхүл хамтран өмчлөх эд хөрөнгө, гэрлэлтийн гэрээ, хамтын амьдралыг гэрлэлттэй адилтгах, мэс заслын аргаар хүйсээ өөрчлөхөд гэрлэлт дуусгавар болох, тээгч эхээр хүүхэд тээлгэх, зохиомлоор үр суулгах гэхчилэн нөхөн үржихүйн туслах аргыг ашиглан хүүхэдтэй болох гэх мэт шинээр үүсэж буй харилцааг тусгайлсан гэр бүлийн хуулиар зохицуулж байна.

1.2. Практик хэрэгцээ, шаардлага

Гэр бүлийн харилцааны эрх зүйн орчныг сайжруулах, гэр бүлийн харилцаанд тулгамдаж байгаа асуудлуудыг шийдвэрлэх зорилгоор Гэр бүлийн тухай хуулийг шинэчлэн найруулах дараах практик шаардлага зүй ёсоор тавигдаж байна. Үүнд:

1/Монгол Улсад гэрлэлт цуцлалтын хувь хэмжээ жил ирэх тусам нэмэгдэж байгаа хэдий ч гэрлэлт цуцлахдаа хүүхдийн асуудлыг хамтад нь шийдвэрлэхгүй байх тохиолдол цөөнгүй байна. Үүнээс шалтгаалан гэрлэлт цуцлахад хүүхдийн хууль ёсны эрх, ашиг сонирхол зөрчигдөх, эцэг, эх байх хариуцлага сулрах, гэр бүлийн хариуцлагын талаарх нийгэм дэх ойлголт улам доошилж, энэ нь эргээд төлөвлөлтгүй гэр бүл болох, хүүхдийн хууль ёсны эрх, ашиг сонирхол ноцтой зөрчигдөхөд хүргэж байна.

Тухайлбал, 2022 онд 17694, 2023 онд 17596, 2024 онд 14165 гэрлэлт бүртгэгдсэн байна. Мөн 2022 онд 4515, 2023 онд 4825, 2024 онд 4459 гэрлэлт дуусгавар болсон байна.

Өөрөөр хэлбэл, гэрлэлт дуусгавар болсон тохиолдлын гэрлэлт бүртгэлд харгалзах хувь 2022 онд 25.5 хувь, 2023 онд 27.4 хувь, 2024 онд 31.4 хувь буюу гэрлэлт дуусгавар болох нь жил ирэх тусам нэмэгдэж байна.

2/Шүүх гэрлэлт цуцлах тухай шийдвэр гаргахдаа тухайн гэрлэгчид хүүхэдтэй бол нэхэмжлэлийн шаардлагаас үл хамаарч хүүхдийн тэтгэлэг тогтоох, шаардлагатай тохиолдолд хүүхдэд асран хамгаалагч, харгалзан дэмжигч томилох, хүүхдээс тусдаа амьдарч байгаа эцэг, эсхүл эхийн эрх, үүрэг, хариуцлага, хүүхэдтэйгээ уулзах, хугацаа нөхцөл зэргийг хамтад нь шийдвэрлэх зохицуулалт шаардлагатай болсон.

Гэрлэлт цуцлуулах тухай нэхэмжлэл гаргахдаа хүүхдийн тэтгэлэг гаргуулах талаар давхар нэхэмжлээгүй 2017 оны 50 шүүхийн шийдвэрийг түүвэрлэн судлахад, 10 шийдвэр буюу 20 хувь нь хүүхдийн тэтгэлэг гаргуулахаар шийдвэрлэж, 40 шүүхийн шийдвэр буюу 80 хувь нь хүүхдийн тэтгэлгийг шийдэлгүй шүүх шийдвэрээ гаргасан байна.¹⁴

Гэтэл гэрлэлт цуцлуулах тухай нэхэмжлэл гаргахдаа хүүхдийн тэтгэлэг гаргуулах талаар давхар нэхэмжлээгүй 2022 оны 50 шүүхийн шийдвэрийг түүвэрлэн судлахад, хүүхдийн тэтгэлэг гаргуулж шийдвэрлэсэн 5 шүүхийн шийдвэр буюу 10 хувь, 45 шүүхийн шийдвэр буюу нийт шүүхийн шийдвэрийн 90 хувь нь хүүхдийн тэтгэлгийг шийдвэрлэлгүй орхигдуулсан байна.

¹⁴ Гэр бүлийн харилцаанаас үүссэн зарим төрлийн иргэний хэргийн шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ, 19 дэх тал.


Эндээс үзэхэд, гэрлэлт цуцлахдаа хүүхдийн тэтгэлгийг тогтоогоогүй гэрлэлтийг цуцалсан шүүхийн шийдвэрийн хувь 2017 онд нийт түүвэрлэсэн шүүхийн шийдвэрийн 20 хувь байсан бол, 2022 онд энэ хувь 10 хувь болж буурсан байна.¹⁵

Тухайлбал, 2023 оны 11 дүгээр сарын 06-ны өдрийн Баянзүрх дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүхийн 101/ШШ2023/04812 дугаар шийдвэрээр гэрлэлт цуцлахдаа нэхэмжлэгч нэхэмжлэлдээ хүүхдийн тэтгэлэг гаргуулах талаар тусгаагүй гэх үндэслэлээр шүүх хүүхдийн тэтгэлгийг шийдвэрлээгүй орхисон байна.¹⁶

3/2021 онд 11280 гүйцэтгэх хуудаснаас 11.3 хувь биелсэн буюу нийт төлбөл зохих 33,978,414.6 төгрөгийн мөнгөн дүнгийн 51.7 хувь нь биелсэн байна. 2022 онд 12246 гүйцэтгэх хуудаснаас 8.7 хувь нь биелсэн буюу нийт төлбөл зохих 28,337,140.5 төгрөгөөс 38.9 хувь нь мөнгөн дүнгийн хувьд биелсэн байна.

Харин 2023 онд 13144 гүйцэтгэх хуудаснаас 7.3 хувь биелсэн бөгөөд мөнгөн дүнгээр 29,872,660.4 төгрөгөөс 40.9 хувь нь биелсэн бол 2024 онд 15435 гүйцэтгэх хуудаснаас 9 хувь нь биелсэн буюу 29,423,192.0 төгрөгөөс 11.7 хувь нь биелсэн үзүүлэлттэй¹⁷ байна.

Сүүлийн 4 жилийн дундаж үзүүлэлтийг үзвэл гүйцэтгэвэл зохих нийт хүүхдийн тэтгэлэг гаргуулах гүйцэтгэх хуудаснаас 9 хувь нь л биелсэн үзүүлэлттэй буюу туйлын хангалтгүй байна.



Эндээс үзэхэд, гэрлэлт цуцлуулах нэхэмжлэлээс тусад нь хүүхдийн тэтгэлэг тогтоолгох тухай нэхэмжлэл гаргаж, шүүх шийдвэрлэсэн хүүхдийн тэтгэлэг тогтоолгох хэрэг 2021 онд 1333, 2022 онд 1774, 2023 онд 1571, 2024 онд 1924 байна.

¹⁵ Гэр бүлийн харилцаанаас үүссэн зарим төрлийн иргэний хэргийн шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ, 19 дэх тал.

¹⁶ Shuukh.mn

¹⁷ ШШГЕГ-аас ирүүлсэн статистик мэдээлэл.

Өөрөөр хэлбэл, гэрлэлт цуцлуулах нэхэмжлэлээс тусдаа нэхэмжлэлээр шүүхэд хянан шийдвэрлэгдэж байгаа хүүхдийн тэтгэлэг тогтоолгох асуудлаар гаргасан нэхэмжлэл жил ирэх тусам нэмэгдэж байгааг харуулж байна.¹⁸

Гэр бүлийн тухай хуулийн 40 дүгээр зүйлд зааснаар хүүхдэд олгох тэтгэлгийг түүний насны байдлыг харгалзан сард нэг хүүхдэд дараах хэмжээгээр тогтооно:

- 11 хүртэлх насны хүүхдэд тухайн бүс нутагт тогтоогдсон амьжиргааны доод түвшингийн 50 хувиар;
- 11-16 нас /суралцаж байгаа бол 18 нас/-тай болон насанд хүрсэн боловч хөдөлмөрийн чадваргүй хүүхдэд амьжиргааны доод түвшингийн хэмжээгээр.

Бүс нутаг	Тэтгэлгийн хэмжээ
Баруун бүс	447,100 ₮
Хангайн бүс	447,300 ₮
Төвийн бүс	446,700 ₮
Зүүн бүс	446,400 ₮
Улаанбаатар	454,200 ₮

/Амьжиргааны доод түвшин 2025 оны байдлаар/

Өөрөөр хэлбэл, тогтоогдсон тэтгэлгийн хэмжээ хангалтгүй байгаагаас хүүхдийн наад захын хэрэгцээ хангагдахгүй байх, хоол тэжээлийн доройтолд орох зэргээр хүүхдийн эрүүл, аюулгүй орчинд өсөн бойжих, сурч боловсрох эрх зөрчигдөхөд хүрч байна.

Иймд тэтгэлгийн хэмжээг тэтгэлэг авагчийн нөхцөл, тэтгэлэг төлөгчийн орлого зэрэгтэй уялдуулж, эрх бүхий байгууллагаас батлагдсан аргачлалаар шүүх тогтоох шинэлэг зохицуулалт бий болгох шаардлагатай байна.


4/Монгол Улсын нутаг дэвсгэрт хүн амын 6.1 хувь нь цус ойртсон байх магадлалтай гэсэн судалгаа¹⁹ гарсан нь Монгол хүний удмын сангийн аюулгүй байдлыг хамгаалах асуудал тулгамдаж байгааг харуулж байна. Энэ нь гэрлэхийг хүсэгчид хоорондоо садан төрлийн холбоотой эсэхээ мэдэх боломжийг хангах зохицуулалт бүрдээгүйгээс тодорхой хэмжээнд шалтгаалж байна гэж үзэж байна.

¹⁸ Шүүхийн Ерөнхий Зөвлөлийн даргын 2024 оны 11 дүгээр сарын 01-ний өдрийн албан бичгийн 1 дүгээр хавсралт.

¹⁹ Э.Энхмаа, Монголын хун амын генетик тогтоц, уур амьсгалын хахиршилт ба өвчлөл, нас баралтын хам холбоог газар зүйн байршлаар мөшгин судлах нь, 2010 он.

5/Гэрлэлт цуцлах шалтгааны дийлэнх хувийг гэрлэгчид хоорондын таагүй харилцаа эзэлсэн хэвээр байгаа боловч гэр бүлээс гадуурх харилцаанаас үүдсэн гэрлэлт цуцлах нь 2 хувиас 20 хувь болж эрс өсжээ. Гэр бүлээс гадуурх харилцаанаас болж гэрлэлт цуцлахад сэтгэл санааны хохирол нөхөн төлүүлэх нарийвчилсан эрх зүйн зохицуулалт байхгүй байна.

ГЭРЛЭЛТ ЦУЦЛАХ ШАЛТГААН (50 кейс түүвэрлэн үзэхэд)



Тодруулбал, шүүхийн шийдвэрийн цахим сангаас 2017 ба 2022 онд шийдвэрлэсэн гэрлэлт цуцалсан шүүхийн шийдвэрүүдээс тус тус 50 шийдвэрийг түүвэрлэж,²⁰ гэрлэлт цуцлах болсон шалтгааныг судлан үзэхэд, гэр бүлээс гадуурх харилцаанаас үүдэлтэй гэрлэлт цуцлалт 2017 онд 1 буюу 2 хувь байсан бол энэ нь 2022 онд 10 буюу 20 хувь болсон бөгөөд энэхүү шалтгаан нь гэрлэлт цуцлах шалтгааны 2 дахь томоохон шалтгаан болж байна.

Гэр бүлээс гадуурх харилцааны талаар БНСУ-д хэрхэн зохицуулсныг судлахад, гэрлэгчийн зүй бус үйлдэл нь гэрлэлтийг шүүхийн журмаар цуцлах үндэслэл болох бөгөөд зүй бус үйлдэлд гэр бүлээс гадуурх харилцааг багтаан ойлгодог.²¹

Тодруулбал, гэрлэгчдийн хэн нэг нь гэр бүлээс гадуур харилцаанд орсон үйлдэл нь зүй бус үйлдэлд тооцогдож гэр бүл цуцлах хууль зүйн үндэслэл болохоос гадна гэрлэгчийн сэтгэл санаанд хохирол учруулсан гэж үзэн түүнд нь тохирсон хариуцлага хүлээлгэхээр заасан байна.²²

Иймээс гэр бүлээс гадуурх харилцааны улмаас гэрлэлт цуцлах тохиолдолд буруутай гэрлэгчийн хариуцлагын талаарх хууль, эрх зүйн орчин тодорхойгүй байна.

²⁰ С.Сүхбаатар, Б.Энх-Амгалан, Х.Санчир, Гэр бүлийн харилцаанаас үүссэн зарим төрлийн иргэний хэргийн шүүхийн шийдвэрийн дүн шинжилгээ, Хууль зүйн үндэсний хүрээлэнгийн Судалгааны тайлангийн эмхэтгэл XIII боть, 2023 он, 134-135 дахь тал.

²¹ БНСУ-ын Иргэний хууль https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=61788&lang=ENG

²² БНСУ-ын Иргэний хууль https://elaw.klri.re.kr/eng_service/lawView.do?hseq=61788&lang=ENG

6/Сүүлийн 4 жилийн байдлаар гэрлэлтээ бүртгүүлээгүй эцэг, эхээс төрсөн хүүхэд нийт 99529 бүртгэгдсэнээс 2022 онд 30719, 2023 онд 29145, 2024 онд 27109, 2025 оны хагаст 12556 хүүхэд бүртгэгдсэн байна. Энэхүү статистик тоо баримтаас үзэхэд, хамтран амьдрах (Defacto) хэлбэр түгээмэл болсон байна.

Хамтран амьдрах явцад хамтран амьдрагчид дундын эд хөрөнгөтэй болоход хэрхэн хуваах талаарх эрх зүйн орчин бүрдээгүйгээс хамтран амьдрагчдын эд хөрөнгийн эрх зөрчигдөхөд хүрч байна.

Иймд манай улсын хувьд гэрлэлтээ бүртгүүлээгүй боловч хамтран амьдарч байгаа хүмүүсийн эрх, үүргийг тодорхойлох, цаашлаад эд хөрөнгө хуваах, хүүхэд асрамжийн маргаан үүсэх тохиолдолд хэрхэн шийдвэрлэх эрх зүйн зохицуулалт дутмаг байна.

7/Нөхөн үржихүйн тусгай аргыг хэрэглэж буюу тээгч эх, эсийн донор ашиглаж төрөх асуудал дэлхий нийтэд төдийгүй Монгол Улсад сүүлийн үед ихээхэн гарч байна. Энэ аргыг хэрэглэн төрсөн хүүхдийн эцэг, эхийг тогтоох маргаан их гарч хүндрэл үүсгэж байна. Дээрх харилцааг зохицуулсан эрх зүйн орчин байхгүй байна.

8/Мэс заслын аргаар хүйсээ өөрчлөхөд эхлээд гэрлэлтээ цуцлуулах, дараа нь хүйсийн өөрчлөлтийг бүртгэх хууль, эрх зүйн зохицуулалттай.

2022 оноос одоог хүртэл мэс заслын аргаар хүйсээ солиулсан нийт 5 тохиолдол бүртгэгджээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 11-д зааснаар Монгол Улс ижил хүйсийн гэрлэлтийг хүлээн зөвшөөрдөггүй тул уг шалтгаанаар гэрлэлт дуусгавар болохтой холбоотой харилцааг оновчтой зохицуулах шаардлага үүссэн.

9/2024 оны байдлаар гэр бүлийн орчноос байнга болон түр хугацаагаар тусгаарлагдаж асрамж, халамжийн газарт 895 хүүхэд амьдарч байгаа бөгөөд хараа хяналтгүй 240, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн 203, бэлгийн хүчирхийлэлд өртсөн 390 хүүхэд байна.

Энэ нь хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдсөн тохиолдолд тэдний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах боломжийг хангах, эцэг, эхийн эрх, үүрэг, хариуцлагыг тодорхой болгох зохицуулалт шаардлагатайг харуулж байна.

Сүүлийн 5 жилд эцэг, эх байх эрхийг хассан 81 шүүхийн шийдвэр гарсан²³ нь харьцангуй өндөр үзүүлэлт бөгөөд шүүхийн шийдвэрийн үр дүнд хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдөх нөхцөл үүсэж байна.

Харин эцэг, эх байх эрхийг хасах, хязгаарлахаас хүүхдэд үүсэх үр дагаврыг тооцоолох, хүүхдийн эрх ашгийг хамгаалах, энэхүү хугацаанд хүүхэд тэтгэлэг авах, эцэг, эх байх эрхийг хассан тохиолдолд түүнийг буцаан сэргээх зэрэгтэй холбоотой оновчтой зохицуулалтууд хангалтгүй байна.

²³ ШЕЗ-өөс ирүүлсэн статистик мэдээлэл.

10/Улсын бүртгэлийн байгууллагын мэдээллээр 2017-2022 онд 7596 хүүхэд дотоодод үрчлүүлсэн бол Монгол Улсын харьяат нийт 274 хүүхэд гадаадын иргэдэд үрчлэгдсэн байна.²⁴

Харин 2022-2025 оны хооронд нийт 4843 хүүхэд үрчлүүлснээс Монгол улсын иргэнд 4800 хүүхэд, гадаад улсын иргэнд 43 хүүхэд үрчлүүлсэн байна.

Энэ нь өндөр үзүүлэлт бөгөөд хүүхэд үрчлэлтийн асуудалд хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол хөндөгдөж байдаг. Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулиар гадаад, дотоод үрчлэлтийн асуудлыг эрх бүхий албан тушаалтан шийдвэрлэж байгаа нь цаашид хүүхдийн эрх ашиг зөрчигдөх эрсдэлтэй байна.

Бусад улс орны жишгээс үзэхэд хүүхдийг үрчлэх эсэх асуудлыг зөвхөн шүүх шийдвэрлэдэг байна. Иймд хүүхдийн аливаа эрх ашиг хөндөгдөж байгаа тохиолдолд зөрчигдөхөөс урьдчилан сэргийлэх зорилгоор үрчлэх эсэх асуудлыг шүүхээр шийдвэрлүүлэх нь зүйтэй байна.²⁵

11/1998-2021 оны хооронд Монгол Улсын 7555 иргэн гадаадын иргэдтэй гэр бүл болсон бол 1513 иргэн гэрлэлтээ цуцлуулсан байна. 2022 онд 367 иргэн гадаадын иргэнтэй Монгол Улсад гэрлэлтээ бүртгүүлсэн байна.²⁶

2022 онд 17585, 2023 онд 17440, 2024 онд 14238 Монгол Улсын иргэн гадаадын иргэнтэй гэр бүл болсон бол 2022 онд 4556, 2023 онд 4781, 2024 онд 4466 гадаадыг иргэнтэй гэрлэсэн Монгол Улсын иргэн гэрлэлтээ дуусгавар болгожээ.

Эндээс үзэхэд, Монгол Улсын иргэн гадаадын иргэнтэй гэрлэлт бүртгүүлэх, мөн гэрлэлт дуусгавар болгох харилцаа өсөн нэмэгдэж байна.

Гэр бүлийн асуудлаар явуулсан судалгаанд оролцогчдын 46.2% нь “даяаршсан нийгэмд гадаад хүнтэй гэрлэхийг байх л асуудал” гэж үзэж байгаа нь цаашид гадаадын иргэнтэй гэрлэх тоо нэмэгдэх хандлагатай байгааг харуулж байна. Гэтэл практикт гадаадын иргэнтэй гэр бүл болох, гэрлэлт цуцлах, хүүхдийн асрамж, тэтгэлэг, хөрөнгийн маргааныг шийдвэрлэхэд олон улсын чиг хандлага, Монгол Улсын олон улсын гэрээ, конвенцод нийцсэн эрх зүйн оновчтой зохицуулалт шаардлагатай байна.

12/Манай улсын хувьд хүүхдийн асрамжийн биечлэн дангаар асрах зохицуулалт байдаг бөгөөд хүүхдийн асрамжийн дангаар болон хамтран хэрэгжүүлэх хувилбарыг бий болгох шаардлага үүссэн. Ингэснээр дангаар биечлэн, мөн дангаар хүүхдийн талаарх шийдвэр гаргах /sole legal and physical custody/, дангаар биечлэн гэхдээ хамтран хүүхдийн талаар шийдвэр гаргах /sole physical and joint legal custody/, хамтран эдгээрийг хэрэгжүүлэх /sole joint custody/ гэх хэлбэрүүд олон улсад байдгийг Монгол Улсад бий болгох, улмаар хүүхдийн асрамжийг оновчтой шийдвэрлэх хувилбаруудыг бий болгоно.

Иймд гэр бүлийн харилцааны эрх зүйн зохицуулалтыг олон улсын жишигт нийцүүлэх, шинээр үүсэж байгаа харилцааг зохицуулах, хуулийн зөрчил, хийдлийг

²⁴ Улсын бүртгэлийн ерөнхий газраас ирүүлсэн мэдээлэл.

²⁵ БНСУ-ын Гэр бүлийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль
https://elaw.klri.re.kr/eng_mobile/subjectViewer.do?hseq=1081&type=subject&key=01&pCode=12&pName=Guardianship

²⁶ Улсын бүртгэлийн ерөнхий газраас ирүүлсэн мэдээлэл.

арилгах зорилгоор Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулна.

Хоёр.Хуулийн төслийн зорилго, ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Энэ хуулийн төслийн зорилго нь хүүхэд, жирэмсэн болон хөхүүл эмэгтэй, эсхүл бага насны хүүхэдтэй, өрх толгойлсон эцэг, эх, эсхүл хөгжлийн бэрхшээлтэй, ахмад настан, хөдөлмөрийн чадваргүй гэр бүлийн гишүүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг тэргүүн ээлжид хамгаалах, шинэ тутам үүсэж байгаа гэр бүлийн эрх зүйн харилцааг бүрэн зохицуулахад чиглэнэ.

Тус хуулийн төслөөр гэрлэх, гэрлэлт дуусгавар болох, гэрлэлтийн гэрээ, гэр бүлийн гишүүдийн эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус эрх, үүрэг, хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалах, тэжээн тэтгэх, асран хамгаалах, харгалзан дэмжих, хүүхдийн нэр, эцэг /эх/-ийн нэр, овог, эцэг, эх тогтоох, эцэг, эх байх эрхийг хязгаарлах, хасах, сэргээх, хүүхэд үрчлэхтэй холбогдсон гэр бүлийн эрх зүйн харилцааг зохицуулна.

Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлд гэрлэлт, гэрлэлт дуусгавар болох, гэр бүлийн гишүүний эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус амины эрх, үүрэг, тэжээн тэтгэх, асран хамгаалах, харгалзан дэмжих, хүүхэд үрчлэхтэй холбоотой харилцааг зохицуулах эрх зүйн орчныг дараах байдлаар бүрдүүлнэ. Үүнд:

- Нийтлэг үндэслэл болох хуулийн зорилт, нэр томъёоны тодорхойлолт, гэр бүлийн харилцаанд баримтлах зарчмын талаар тусгана.

- Гэрлэх, гэрлэхэд харшлах шалтгаан, гэрлэлтийн бүртгэл, гэрлэгчдийн эрх, үүрэг зэргийг нарийвчлан тодорхойлж тусгана;

- Гэрлэлт дуусгавар болох, цуцлах, гэрлэлт болон гэрлэлт цуцлалтыг хүчин төгөлдөр бусад тооцох, тэдгээрийн үр дагавар, эд хөрөнгө хуваах, гэрлэлттэй адилтгах харилцаа зэргийг тусгана. Мөн шүүх гэрлэлт цуцлах шийдвэр гаргахдаа шалтгаан, нөхцөлийг харгалзан тэргүүн ээлжид хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй, хөдөлмөрийн чадваргүй гэр бүлийн гишүүний эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хангах зарчмыг баримтлах эрх зүйн орчныг боловсронгуй болгоно;

- Гэрлэлтийн гэрээ байгуулах, түүний хэлбэр, зохицуулах асуудлыг шинээр тусгана;

- Хүүхдэд овог, нэр өгөх, өөрчлөх, эцэг, эхийг тогтоохтой холбогдсон харилцааг нарийвчлан зохицуулна;

- Хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, зөрчигдсөн тохиолдолд шаардах эрхийг хэрэгжүүлэх боломжийг хангах, эцэг, эхийн эрх, үүрэг, хариуцлага, тэдний эцэг, эх байх эрхийг хязгаарлах, хасах, үүний үр дагавар, сэргээх, дуусгавар болох харилцааг зохицуулсан зохицуулалтыг тусгана. Мөн хүүхдээс тусдаа амьдарч байгаа эцэг, эх, садан, төрлийн харилцаа зэрэг асуудлыг тодорхой зохицуулж, баталгаажуулна;

– Гэрлэгчид бие биеэ, эцэг, эх хүүхдээ тэжээн тэтгэх эрх, үүрэг, тэтгэлгийн хэмжээ, олгох хугацаа, хэлбэр, тэдгээрийг хэрэгжүүлэх гэрээ, түүнийг өөрчлөх, цуцлах, мөн эрхээ шүүхээр хамгаалуулахтай холбоотой харилцааг зохицуулсан зохицуулалтыг тусгана;

– Асран хамгаалах, харгалзан дэмжүүлэх хүн болон асран хамгаалагч, харгалзан дэмжигч, асралт гэр бүлийг тодорхойлж, тэдгээрийн эрх, үүргийг тусгана. Мөн асран хамгаалагч, харгалзан дэмжигчийг тогтоох, томилох, мөн тэдний эрхийн хязгаарлалт, асран хамгаалуулагч, харгалзан дэмжүүлэгчийн эд хөрөнгийг зарцуулах, хамгаалах асуудлуудыг нарийвчлан зохицуулна;

– Эцэг, эх хууль ёсны төлөөлөгч, асран хамгаалагчийн зөвшөөрлийн үндсэн дээр хүүхэд үрчлүүлэх, үрчлэлтийн харилцаанд баримтлах зарчим, үрчлүүлэх журам, үрчлэгч, үрчлүүлэгчийн эрх, үүрэг, хууль ёсны ашиг сонирхол, үрчлэлтийн хяналт, бүртгэл, үрчлэлтээс үүсэх үр дагавар, үрчлэлтийг хүчингүй болгох зэрэг зохицуулалтыг нарийвчлан тусгана. Хүүхдийг үрчлүүлэх эсэхийг үрчлэлтийн асуудал хариуцсан орон тооны бус үрчлэлтийн зөвлөлийн дүгнэлтийг үндэслэн шүүх шийдвэрлэдэг байх зохицуулалтыг шинээр тусгана;

– Олон улсын гэр бүлийн харилцаанд гэр бүлийн хууль тогтоомжийн хэрэглээг тусгах бөгөөд Монгол Улсын нутаг дэвсгэрт гадаадын иргэн, харьяалалгүй иргэнтэй гэрлэлт бүртгүүлэх, гадаад улсад гэрлэлт бүртгүүлэх, дуусгавар болгох, эдгээрийн эд хөрөнгийн харилцаа, эцэг, эх хүүхдийн харилцаа, эцэг, эх тогтоох, тэжээн тэтгэх, асран хамгаалах, харгалзан дэмжих, гадаад улсын иргэнд хүүхэд үрчлүүлэх, тэдэнд тавих хяналт зэрэг холбогдох харилцааг зохицуулж байгаа зохицуулалтыг тусгана;

– Хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээд, албан тушаалтны үйлдэлд холбогдох хуульд заасан хариуцлага, дагаж мөрдөх журам болон хууль хүчин төгөлдөр болох зохицуулалтыг тус тус тусгана.

Гурав.Хууль батлагдсаны дараа үүсэж болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал

Хуулийн төсөл батлагдсанаар гэрлэх, гэрлэлт дуусгавар болох, гэр бүлийн гишүүний эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус амины эрх, үүрэг, гэрлэлттэй адилтгах харилцаа, гэрлэлтийн гэрээ, тэжээн тэтгэх гэрээ, тэжээн тэтгэх, тэтгэлэг тогтоолгох, хүүхэд үрчлэхтэй холбоотой харилцаа, асран хамгаалалт, харгалзан дэмжигч тогтоох, асралт гэр бүлд шилжүүлэх харилцаа, хүйсээ солиулсны улмаас гэрлэлт дуусгавар болох, тээгч эхийн асуудал, түүнээс үүсэх үр дагавар, тэдгээрийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах харилцааг нарийвчлан зохицуулах нөхцөл бүрдэнэ. Түүнчлэн хүүхэд үрчлэх асуудалд хүүхдийн эрх ашгийг хамгаалсан үрчлэх нөхцөл, журмыг нарийвчлан зохицуулах эерэг үр дагавар бий болно.

Гэр бүлийн гишүүд болон хүүхдийн эрх ашгийг хамгаалах зорилгоор тус хуульд заасан зарим тохиолдолд эрх хязгаарлах зохицуулалтыг тусгах ба үүнээс үүсэх үр дагаврыг тооцож, оролцогчдын эрх ашгийг аль болох хөндөхгүй байх, хамгаалах зохицуулалтыг тусгаж шийдвэрлэнэ.

Ийнхүү гэр бүлийн харилцааны олон талт асуудлыг хуулиар нарийвчлан зохицуулснаар гэр бүлийн гишүүдийн, ялангуяа хүүхдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол тэнцвэртэй хангагдана.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаар

Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээтэй нийцүүлэн боловсруулах бөгөөд хуулийн төсөлтэй холбогдуулан Гэр бүлийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай, Иргэний улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Иргэний хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Эвлэрүүлэн зуучлалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай, Хүүхэд хамгааллын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн зарим заалтыг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг тус тус боловсруулна.

—000—